

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2015 ОНЫ I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Авлигатай тэмцэх газар нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, 2015 онд дэвшүүлсэн зорилт, жил, улирлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд эхний улиралд хийгдсэн ажил, хүрсэн үр дүнг тайлагнаж байна. Үүнд:

Удирдлага, зохион байгуулалт, дотоод ажлын чиглэлээр:

Тайлангийн хугацаанд даргын зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, Газрын даргын 63 тушаал батлагдан гарснаас 26 нь хүний нөөцийн чиглэлээр, 37 нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдон гарчээ. Авлигын эсрэг хууль, Улсын Их Хурлын тогтоолыг удирдлага болгон 1 албан хаагчид эрхэлсэн комиссар, 2 албан хаагчид ахлах комиссар, 6 албан хаагчид комиссар, 1 албан хаагчид дэд комиссар зэрэг дэв олгуулах, 7 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон байна.

“Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ын төсөл, “Авто тээврийн хэрэгслийн жолоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”, “Хөдөө орон нутагт ажиллах жолоочид өгөх зөвлөмж, зааварчилгаа” зэргийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу 3 удаагийн сургалтад нийт 17 албан хаагчийг хамруулж, Олон улсын Стар байгууллагын сургагч багш нарыг урьж, холбогдох албан хаагчдыг сургалтанд хамруулсан.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлтэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж тус зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Албан хаагчдын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу хөтөлж, баяжилт хөдөлгөөнийг тухай бүр хийж байгаа бөгөөд Төрийн албаны зөвлөлд 2014 оны бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг хүргүүлсэн.

Байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнуудад тусгай ажиллагаанд оролцохдоо хэрэглэх зориулалтын хувцасны хангалт хийх ажлыг зохион байгуулж, бэлэн болсон хувцасыг хүлээн авч байгууллагын орлогод аваад байна.

Газрын удирдлага болон албан хаагчдыг Арабын Нэгдсэн Эмират, Франц, Сингапур зэрэг улс орнуудад зохион байгуулагдсан авлигын эсрэг олон улсын хурал, сургалт семинар, үзэсгэлэнд оролцуулах ажлыг зохион байгуулав.

Сахилгын болон ёс зүйн зөрчилтэй холбогдох асуудалд хяналт шалгалт хийж, тодорхой арга хэмжээ авч ажиллаа.

Байгууллагын интернэт сүлжээний урсгалыг зохицуулагч төхөөрөмж дээр сүлжээний хязгаарлалт, тохиргоог хийн хэвийн тасалдалгүй ажиллагааг хангахын зэрэгцээ, антивирусийн програм худалдан авч серверт суулган, төвлөрүүлж дотоод сүлжээгээр нийт компьютерт тараан суурилуулсан.

“Бичиг хэрэг, өргөдөл гомдол, эрүүгийн хэргийн бүртгэл, ХАСХОМ-ийн хяналт шалгалтын бүртгэлийн програм”-ыг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс ажилд нэвтрүүлсэн бөгөөд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг гүйцэтгэгч компаниар хийлгэж, серверт суулгах, тохируулах ажлыг хийж гүйцэтгээд байна.

2014 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайлан тэнцлийг гаргаж Сангийн яам, Төрийн өмчийн хороо, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн ба 2014 онд баталсан 3.531.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын тайлан, 2015 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гаргаж Сангийн яаманд хүргүүллээ. 2014 оны жилийн эцсийн хөрөнгө, аж ахуйн материалын тооллого, тооцоог дуусгаж дүнг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Эхний улирлын төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу авч, зарцуулан байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг хангаж ажиллав. 2015 оны баталсан төсөв, төлөвлөгөөг санхүүгийн Acolous, Plastic програмд оруулж, хөрөнгө, санхүүгийн тайланг шилэн дансны болон байгууллагын сайтад байршуулж байна.

Мөрдөн байцаах тусгай өрөө, 1 дүгээр давхрын 9 өрөөний засварын ажлыг “Eco Building Construction” ХХК-иар 71/28 тоот гэрээний дагуу гүйцэтгүүлж, дуу, дүрс дамжуулах төхөөрөмжүүдийг суурилуулж бичлэгийн програм болон серверийг шинэчлэн тохируулсан. Онцгой байдлын ерөнхий газрын хойно баригдаж буй “АТГ-ын тусгай автогараж”-ын барилгын улирлын чанартай хийгдэх ажлыг эхлүүлсэн.

Тайлангийн хугацаанд нийт 50 албан хаагч 187 хоног хөдөө орон нутагт томилолтоор ажилласан байна.

Байгууллагаас зохион байгуулж буй ажил, арга хэмжээний талаар 44 мэдээ болон “Авлигатай тэмцэх газар 2014 онд” нийтлэлийг бичиж хэвлэлд нийтлүүлсэн. Мөн “Авлигатай тэмцэх газар 2015 оны 1 дүгээр сард”, “Авлигатай тэмцэх газар 2015 оны 2 дугаар сард” тоон мэдээллийг флаш баннер хэлбэрээр бэлтгэн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.

Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудас АТГ.мон гэсэн монгол домэйн нэртэй болсон талаарх мэдээллийг олон нийтэд сурталчилж хэлтэс, албадын 2013, 2014 оны үйл ажиллагааны тайлан мэдээллийг шинээр нэмж байршуулав.

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр:

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион

байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилго бүхий “Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу төрийн болон төрийн өмчит байгууллагуудын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааг дүгнэсэн билээ. Үнэлгээний дүнд тулгуурлан 2015 онд анхаарч ажиллах болон хангалтгүй хэрэгжүүлсэн асуудлуудыг тусгасан албан бичгийг нийт үнэлгээнд хамрагдсан 124 байгууллагад хүргүүллээ.

Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын 2014 оны авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнг танилцуулах уулзалтыг Улсын Их Хурлын Тамгын газраас санаачлан хамтран зохион байгуулсан бөгөөд үнэлгээ хийх аргачлал, үнэлгээний дүн болон нийтлэг дутагдал, цаашид анхаарч ажиллах асуудлуудын талаар “Онч шийдэл” төрийн бус байгууллагатай хамтран уулзалтанд оролцогчдод танилцуулав.

Аргачлал ёсоор албан байгууллагууд 2015 оны 2 дугаар сардаа багтаан байгууллагынхаа 2015 оны “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Авлигатай тэмцэх газарт ирүүлэх үүрэгтэй ба Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн салбар хариуцсан ажилтнууд байгууллага бүрт төлөвлөх ажилд нь арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар 2015 оны 3 дугаар сарын 25-ны байдлаар төрийн 81 байгууллагаас 74 нь, төрийн болон төрийн өмчийн оролцоотой 47, нийт 121 байгууллага 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг боловсруулж дуусгалаа. Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг Шилэн дансны тухай хууль, шинжээчдийн багаас өгсөн зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан баталгаажуулахаар бэлтгэж байгаа бөгөөд үнэлгээнд хамрагддаг байгууллагуудын нөхцөл байдлын судалгааг гаргахаар ажиллаж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээгээр хангалтгүй үнэлгээ авсан Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Гадаад хэргийн яам, Эрүүл мэнд, спортын яам, Мал эмнэлэг үржлийн газар зэрэг байгууллагын удирдлагуудад цаашид үнэлгээгээ ахиулах, санаачилгатай ажиллах талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан бөгөөд хангалтгүй үнэлгээ авсан Мал эмнэлэг, үржлийн газар, Налайх дүүрэг, Сангийн яам, Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар, Барилгын хөгжлийн төв, Ховд, Говь-Алтай, Увс аймагт тус тус ажлын хэсэг гарган ажиллууллаа.

Мал эмнэлэг үржлийн газар

Мал эмнэлэг үржлийн газарт “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг таниулах, 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, тайлагнахад анхаарах асуудлууд болон нотлох баримтыг ирүүлэхдээ анхаарах асуудлуудыг нэг бүрчилэн тайлбарлан, байгууллагын цахим хуудсаа иргэд, олон нийт хандахад зориулан хялбар болгох, бусад мэдээллийг хангалттай байршуулдаг байгууллагуудын цахим хуудсуудыг тандах, сайн туршлагыг өөрийн байгууллагад нэвтрүүлэх чиглэлээр зөвлөгөө өгсөн. Энэхүү ажлын хүрээнд “Мал эмнэлгийн зайлшгүй шаардлагатай эм болон эмнэлгийн хэрэгслийн жагсаалт, Малын эмийн улсын бүртгэлийн жагсаалт, Малын эмийн улсын бүртгэлийн дүрэм, Мал эмнэлгийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн жагсаалт” зэргийг ил тод, нээлттэй болгууллаа.

Мөн авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалт зохион байгуулах хөтөлбөр боловсруулан Авлигын шалтгаан хор, хөнөөл, Төрийн байгууллагын ил тод байдал, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэсэн сэдвээр тус газрын нийт албан хаагч нарт сургалт зохион байгууллаа.

Налайх дүүрэг

Нийслэлийн Налайх дүүрэгт авлигын эсрэг үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, арга зүйн удирдлагаар хангах, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, хууль тогтоомжуудыг сурталчлах, судалгааны дүн танилцуулах, судалгаа авах зорилгоор баталсан удирдамжийн дагуу 2015 оны 2 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд ажиллалаа.

Ажлын хэсгийн удирдамжийг Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, дүүргийн Засаг дарга, Тамгын газрын дарга болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын дарга, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагуудад танилцуулан мэдээлэл өгсөн бөгөөд нийт 39 байгууллагын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцан авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд нь арга зүйн зөвлөгөө өгсөн. Нийт 39 төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн 137 албан тушаалтанд авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалт, 40 албан тушаалтныг оролцуулсан асуулт хариултын АХА тэмцээнийг зохион байгуулав. Мөн Авлигатай тэмцэх газраас хийгддэг судалгааны дүн танилцуулсны зэрэгцээ ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн 450 сурагчдад “Шударга хүний 7 дадал” лекцийг илтгэгч багш Ү.Амарбатаар уншуулан хүргэв. Түүнчлэн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад зориулан тус газраас боловсруулсан гарын авлага болох “Найзын яриа”,

“Баадай ба түүний гэр бүлийн ашиг сонирхлын зөрчил” товхимолыг ашиглан нийт 5 дунд сургуулийн 10 ангид ангийн ажил зохион байгуулав.

Тус дүүргийн хувьд зарим удирдах албан тушаалтнууд нь шагнаж урамшуулал олгох явцдаа өөртэйгээ холбоотой тушаал шийдвэрүүд гаргасан байсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг зөрчсөн үйлдэл болж байна. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 буюу албан тушаалтнууд захиргааны акт гаргах, гэрээ, хяналт шалгалт хийхийн өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргахгүй байгаагийн зэрэгцээ эрх бүхий албан тушаалтнууд мэдэгдлийг бүртгэхгүй, албан тушаалтнуудад таниулахгүй байгаа нь хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт хэрэгжихгүй байх үндэслэл болж байгааг таниулж, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг анхааруулан, илэрсэн зөрчлүүдийг арилгуулан энэ тухай мэдээллүүдээр 3 удаа хэвлэлийн мэдээ болгон цахим хуудсанд байршуулсаны дагуу одоогийн байдлаар 547 хандагч бүртгэгдсэн байна. Үүнд:

- Налайх дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямсүрэн, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбат, Эрүүл мэндийн төвийн дарга Б.Эрдэнэбат нар нь өөртөө урамшуулал олгосон үйлдэлийг харьяа дээд шатны байгууллагууд руу Авлигатай тэмцэх газраас албан бичиг хүргүүлсэн бөгөөд энэ дагуу Налайх дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямсүрэнг албан үүргээс нь чөлөөлж, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбатын үндсэн цалинг 1 сарын хугацаатай 30 хувиар бууруулж, Эрүүл мэндийн төвийн дарга Б.Эрдэнэбатын үндсэн цалинг 3 сарын хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан байна.
- Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгч 7 гишүүнд 2013 онд сар бүр 15 000, нийт 1 080 000 төгрөгийг, 2014 оны эхний 3 улиралд нийт 810 000 төгрөгийн урамшууллыг ямар ч үндэслэлгүйгээр олгосон зөрчлийг арилгуулах чиглэлээр албан бичиг хүргүүлсэний дагуу Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд сар бүр олгож байсан 15 мянган төгрөгийг 2015 оноос эхлэн олгохгүй байх тухай асуудлыг ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа тухай мэдэгдсэн байна.ажээ. Түүнчлэн “Налайх дүүргийн Хурлын байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах журам”-ыг хүчингүй болгож, шинэчилсэн журмыг хэлэлцүүлэх, ИТХ-ын нягтлан бодогчийн ажлын байрны давхардлыг салгах зэргээр авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахаа мэдэгдлээ.
- Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт сургалт зохион байгуулах” нэрээр 1 412 300 төгрөгийг шинэ жилийн арга хэмжээнд зарцуулсан нь Хурлын

Тэргүүлэгчдийн ёс зүйг зөрчсөн үйлдэл болсон тул дахин ийм алдаа дутагдал гаргахгүй ажиллахыг Хурлын даргаас үүрэг болгосон байна.

Сангийн яам

Сангийн Яаманд авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Сургалтын тусгайлсан хөтөлбөр боловсруулан, нийт 67 албан тушаалтанд авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах сургалт, Авлигатай тэмцэх газраас хийгддэг судалгааны дүнгийн талаар мэдээлэл хүргэх ажлыг Судалгаа шинжилгээний албатай хамтран зохион байгуулав. 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааг тайлагнахад анхаарах асуудлууд болон нотлох баримтыг ирүүлэхдээ анхаарах асуудлуудыг нэг бүрчилэн тайлбарлаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн цахим хуудаст аргачлалын дагуу дүн шинжилгээ хийж, асуудал бүр дээр зохих зөвлөгөө өгөхийн зэрэгцээ цаашид ил тод, нээлттэй болгох мэдээллүүдийн талаар мэдээлэл арга зүйгээр хангалаа.

Сангийн сайдын 2014 оны 112 дугаар тушаалаар, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 18 дугаар тэмдэглэл, Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн 01 тоот хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Төрийн банкны ТУЗ-ын даргын цалинг 2,000,000 /хоёр сая төгрөгөөр/, гишүүдийн цалинг 1,500,000 /нэг сая таван зуун мянган төгрөг/-өөр тогтоон олгохоор шийдвэрлэсэн байх ба мөн ажлын хэсгийн авсан судалгаагаар тус яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын дарга болон Төрийн сангийн газрын хэлтсийн дарга нь тус бүр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 3 хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.1.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон төрийн захиргааны албан хаагчийн нэг сарын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (нэг сарын)-г хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар тогтоох”, 2.1.2-д “төрийн захиргааны албан хаагчийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 2 хүртлэх хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчөөр томилон ажлуулж байхаар тоог хязгаарлах”-ыг Төрийн өмчийн хороонд даалгаж, чиглэл болгосоныг зөрчиж байгаа нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.7-д заасан авлигын зөрчлийн шинжтэй байх тул холбогдох шийдвэрүүдийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах талаар Сангийн сайд болон Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус зөвлөмж хүргүүлсэн.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газар

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газрын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцахад тус газрын дарга 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдөр салбарын статистик, эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 3 дугаар сарын 31-ны өдөр дотоод сүлжээ, вэбийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 9 дугаар сарын 24-ны өдөр статистик мэдээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн, 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдөр мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн тогтолцоо хариуцсан мэргэжилтнийг тус тус ажилд томилох тушаал гаргасан байх бөгөөд эдгээр төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, холбогдох сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах зэрэг хуулиар хүлээсэн үүргүүдээ хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил, дутагдалтай байгааг арилгуулах, зөрчлийг цаашид дахин гаргахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүллээ.

Мөн Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газрын дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын хамтарсан тушаалаар баталсан Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн ажлын алба байгуулсан асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргад холбогдох мэдээллийг албан бичгээр хүргүүлж ажилласан.

Барилга хөгжлийн төв

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд хөндлөнгийн “Шинжээчдийн баг”-аас хийсэн Үнэлгээний дүнгийн мөрөөр Барилгын хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, чиг үүргийг судлан танилцах зорилгоор газар дээр нь биечлэн ажиллав. Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлсэн Хөндлөнгийн шинжээчдийн багийн үнэлгээгээр төрийн өмчит компаниудын хүлээсэн үүргийн биелэлт 70 оноо авах ёстойгоос дунджаар 39.7 оноо, авлигатай тэмцэх санал санаачлагын биелэлтээр 30 оноо авах ёстойгоос дунджаар 15.2 оноогоор үнэлүүлсэн бодит байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулахыг зорьсоны зэрэгцээ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд авлигын эсрэг хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод байдлыг хуульд заасан хугацаа, шаардлагын зохих түвшинд ил тод, нээлттэй болгож хэвшүүлэх, авлигад өртөх эрсдэлтэй байгууллагын хувьд эрсдэлд өртөх ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлах зэргийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар зөвлөмж өглөө.

Мөн хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ хийх эрхлэх тусгай

зөвшөөрөл олгох журмын хүрээнд явуулж байгаа үйлчилгээнд иргэдээс үндэслэлгүй хурааж байгаа 20 000 төгрөгийн хураамжийг таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэх иргэн, аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалттай холбогдох журмыг ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, гэрчилгээний олголт, сунгалт, нэмэлт ажил бүхий мэдээллүүд хугацааны хамт нээлттэй болгох зэрэгт анхаарч ажиллах талаар мэдэгдсэн бөгөөд цахим хуудсанд энэ талаархи мэдээллийг тавьсан бөгөөд одоогийн байдлаар 335 иргэн, сонирхогч хүмүүс хандсан байна.

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажлын хэсэг 2015 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс Говь-Алтай, Ховд, Увс аймагт авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, арга зүйн удирдлагаар хангах, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, хууль тогтоомжуудыг сурталчлах зорилгоор албан томилолтоор ажиллаж байна.

Мөрдөн байцаагчийн мэдэгдлийн мөрөөр

Мөрдөн байцаагчаас гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн 8 мэдэгдлийг Мөрдөн шалгах хэлтсийн 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 20 дугаар албан бичгээр хүлээн авч, түүний хэрэгжилтийн байдлыг судлан үзлээ. Мэдэгдэл хүргүүлсэн 8 байгууллагын 4 нь Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн, 4 нь орон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтнууд байх бөгөөд гэмт хэрэгт холбогдсон нийт 19 албан тушаалтны дийлэнхи нь цагдаа, гааль, иргэний харьяал, шилжилт хөдөлгөөний газрын байцаагчид байна.

Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлүүдийг арилгуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдалтай биечлэн танилцлах ажлыг хийлээ.

Мөрдөн байцаагчийн мэдэгдлийн мөрөөр Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвөөс авч хэрэгжүүлсэн ажлыг хянан үзэхэд байгууллагын төсвийн зарцуулалт, түүнд тавигдах хяналтыг сайжруулах зорилгоор тухайн жилийн төсөв, түүний зарцуулалтыг зардлын зүйл ангиар, хөрөнгө оруулалт, хандив тусламжаар ирсэн хөрөнгийг жагсаалтаар нь, ажилчдын цалин, нэмэгдэл хөлс, унаа хоолны хөнгөлөлт зэргийг нарийвчлан тооцдог цалингийн "Payroll" программ ашигладаг болсон нь санхүүгийн ажилтнууд хууль зөрчих явдлыг таслан зогсоох, хариуцлагыг дээшлүүлэх бодитой нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлж байгаа бөгөөд байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт төсвийн зарцуулалтын мэдээг

байршуулан иргэд олон нийтэд ил тод болгосон байна. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газар, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын болон төслийн хүрээнд хандивлагдсан тусламж, хөрөнгийг тухай бүрт нь үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын зохих бүртгэлд оруулжээ. Байгууллагын Ерөнхий нягтлан бодогч ажилчдын цалин бодолтын өмнө тасаг нэгжийн ажилан албан хаагчдын ажилласан өдрийн цагийн балансыг тасгийн эрхлэгчээр нь гаргуулан авч цагийн бүртгэл, байгууллагын даргын тушаал, холбогдох хууль тогтоомж шийдвэрийг үндэслэн цалин хөлсийг олгодог болсон, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахын тулд анхан шатны бүртгэлийг хариуцан хөтлөх график, баримт эргэлтийн график, ажиллах ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан төвийн даргаар батлуулан санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгож, нийлүүлэгч байгууллагаас ирсэн бараа материалыг тухай бүр нь орлогод авч, зарцуулалтыг шаардах хуудсаар гарган үлдэгдлийн тайланг сар бүр тогтмол гаргаж, нярвын үлдэгдлийг тоолж баталгаажуулдаг, мөн бэлэн барааны бүртгэлийг хөтөлж хэвшсэн зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь нягтлан бодох бүртгэлийн хүрээнд санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, хяналтыг сайжруулж, санхүүгийн эмх цэгцийг зохих түвшинд хүргэсэн байна.

Мөн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргаас эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмчээр сар бүр 200 мянга, санхүүгийн зөвлөхөөр сар бүр 700 мянга, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерээр сар бүр 300 мянга, цитологич эмчээр сар бүр 500 мянга, хуулийн зөвлөхөөр сар бүр 400 мянган төгрөгийн ажлын хөлстэйгээр тус тус ажиллуулах шийдвэр гаргаж, ажил гүйцэтгэгч нартай “Хөлсөөр ажиллуулах гэрээ” байгуулан хэрэгжүүлснийг Авлигатай тэмцэх газраас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн, мөн “Хөлсөөр ажиллах гэрээ”-ээр гүйцэтгэх ажил, үйлчилгээг нээлттэй сонгон шалгаруулалтаар ил тод зарлах зарчмыг баримтлаагүй гэж үзэж, энэ талын холбогдох тушаалуудыг хүчингүй болгуулж, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах зарчмаар хэрэгжүүлэх саналаа хүргүүлсэний дагуу Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/22 дугаар тушаалаар хууль зөрчсөн дээрх гэрээнүүдээ цуцалж, холбогдон гарсан 5 тушаалыг хүчингүй болгосноо бичгээр мэдэгдлээ.

Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс ирүүлсэн 2014 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд төрийн байгууллагуудад зөрчил арилгуулах болон хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн 63 албан тушаалтны бүртгэл судалгааг хүлээн авч, авлига, ашиг сонирхлын зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж судлан үзэхэд зөрчилд хариуцлага тооцуулсан 63 албан тушаалтны 41 нь буюу 65 хувь нь Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө

орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн чиглэлээр, 22 буюу 35 хувь нь хяналт шалгалт, гомдол мэдээллийн мөрөөр тус тус зөрчлүүд илэрчээ.

Харин тус хэлтсийн гомдол мэдээллийн мөрөөр буюу Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын чиглэлээр ашиг сонирхлын зөрчил гаргасан нийт 21 албан тушаалтны 18 буюу 85 хувь нь төрийн байгууллагын, 3 буюу 15 хувь нь төрийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтнууд байх бөгөөд тэдгээрийн 17 буюу 80 хувь нь удирдах албан тушаалтан 4 буюу 20 хувь нь гүйцэтгэх албан тушаалтнууд байна.

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс дээрх зөрчил гарч байгаа байгууллагуудын удирдлагуудад авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд холбогдох бүртгэл, судалгаа бий болгох талаарх “Зөвлөмж”-ийг хүргүүлэх, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөр хариуцлага тооцсон албан тушаалтныг /Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаал/ мэдээлсэн эсэхэд хяналт тавьж, журмын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах ажлыг хийж эхлүүлээд байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр гарсан мэдээлэлтэй холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд Говь-Алтай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Эрүүл Ус" төслийн хүрээнд цэвэр ус үйлдвэрлэх болсон ба уг арга хэмжээний нээлтэд оролцсон, уг усны шошго дээр Говь-Алтай аймгийн Ардчилсан намын дарга, Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар” гэсэн цээж зурагтай хэвлэгдэн гарсан мэдээллийн дагуу уг асуудал нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасан зар сурталчилгаатай холбогдох хориглолт хязгаарлалтыг зөрчсөн талаар Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан бичиг хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт сануулга өгсөн тухай албан бичиг ирүүлсэн.

Хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулах ажлын хүрээнд 2013 оны 12 дугаар 12 дугаар сарын 25-ны өдрийн 229, 2014 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 25 дугаар тушаалуудаар өөртөө удаа дараа урамшуулал олгон, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу “ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах” үүргээ хэрэгжүүлээгүй байх бөгөөд мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “...өөрийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга Ш.Хажидмаад сануулах, мөн хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн Налайх дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбатад сахилгын шийтгэлийг тус тус авахуулжээ. Мөн Баянгол

дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Баянгол дүүрэг байгуулагдсаны 50 жилийн ойд зориулж иргэд байгууллагын өгсөн хандивын орлогыг хүлээн авах, зарцуулах, тайлагнах журам”-ыг хянаж Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015.02.13 өдрийн 06 дугаар тогтоолоор хүчингүй болгуулсан байна.

Соён гэгээрүүлэх чиглэлээр бага насны хүүхдэд тохирсон асуулт зохиож хариултаар нь эвлүүлдэг дүрс хийх замаар puzzle тоглоом зохиох, Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалтын слайд, асуулгыг сургалтад хамрагдаж байгаа бүлэгт тохируулан төрийн албан хаагч, төрийн удирдах албан тушаалтан, төрийн үйлчилгээний албан тушаалтан, эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/, эмч, багш гэж тусгайлан бэлтгэж боловсруулах ажлыг хийсэн байна.

Цагдаагийн ерөнхий газартай хамтран зохион байгуулах хүүхдийн байцаагч, Цагдаа олон нийт хамтын ажиллагааны ажилтанд зориулан зохион байгуулах сургалтын хөтөлбөрт үндэслэн гарын авлага боловсруулах ажлыг эхлүүлсэн бөгөөд эхний улирлын байдлаар нийт 31 байгууллагад 299 ширхэг гарын авлагыг хүргүүллээ. Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах 2015 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан одоогоор 69 байгууллагын 2,268 нийтийн албан тушаалтан сургалтад хамрагдсан байна. Шударга нийгмийн төлөө хамтдаа аяны хүрээнд “Шударга залуу хүний 7 дадал” лекцийг илтгэгч Ү.Амарбатын хамт нийт 619 иргэнд хүргээд байна. Байгууллагын албан ёсны цахим хуудас /www.АТГ.мон/-ны цэсэнд “Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа” мэдээлэл, “Сургалт” цонхонд “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт”, “Авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл”, “Төрийн байгууллагын ил тод байдал”, “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал, анхаарах асуудал” сэдэв бүхий 5 хичээлийг слайд хэлбэрээр оруулав.

Төрийн үйлчилгээний хүнд суртал, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 6 гомдол ирсэнээс 4 хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 2 нь хянан үзэх шатандаа явагдаж байна. Иргэнээс ирүүлсэн гомдлыг шалган, Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн кабинетийн эмч Д.Цэвэлмаагийн гаргасан үйлдэл нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйл болон Эрүүл мэндийн сайдын 2014 оны 223 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.3, 3.4 дэх заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож, сахилгын арга хэмжээг авахуулсан байна.

Мөн иргэн Т.Танягаас “Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв болон бусад салбар дээр хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ авах гэсэн иргэдэд тодорхой төлбөртэйгөөр энгийн болон шуурхай гэсэн үйлчилгээнээс илүү хурдан хугацаанд гэрчилгээ, сунгалтыг гаргаж өгдөг гэх асуудлыг

шалгуулах” мэдээлийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын газар, Гадаадын хөрөнгө оруулалт, Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын ажил байдалтай танилцан холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэний зэрэгцээ Сүхбаатар дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн 100 айлийн цагдаагийн хэсгийн зарим алба хаагчидтай уулзаж тодруулга авч холбогдох хууль тогтоомжоо иргэд, сонирхогч этгээдүүдэд сайн сурталчлах, хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг ил тод нээлттэй болгох зөвлөгөөг УБЕГ-т өгч иргэнд албан бичгээр хариуг хүргүүлж ажилласан байна.

Дэлхийн банк (GPSA-Нийгмийн хариуцлагын дэлхийн түншлэл)-санхүүжилтээр Глоб Интернэшнл Төв ТББ, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Ил тод байдлын түншлэлийн сан (РТФ, АНУ) байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх “МУ-ын боловсролын салбарын ил тод, хариуцлагатай байдал” төслийн ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр хангах, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын (OECD) ЕвроАзийн Өрсөлдөх Чадварыг Дэмжих хөтөлбөрийн (ЕСР) төлөөлөл Монгол улсад томилолтоор ажиллах хугацаанд худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагуудын оролцогчдын хүрээнд “Төрийн худалдан авах ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгуулах, Авлигатай тэмцэх газрын захиалгаар Азийн сангийн санхүүжилтээр хийгдэж байгаа “Бизнесийн орчин дахь авлигын эрсдлийн нарийвчилсан судалгаа”-ны багт туслах зэргээр олон улсын байгууллага, үйл ажиллагаанд хамтран ажиллалаа.

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Б. Бат-Отгон 2015 оны 3 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд Парис хотноо хуралдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний хяналт шинжилгээ, үнэлгээний 16 дахь удаагийн ээлжит уулзалт, 25-26-ны өдрүүдэд болсон Шударга ёсны форумд тус тус оролцож, тус сүлжээнээс ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн явцын тайланг форумд оролцогчдод танилцууллаа.

Судалгаа, шинжилгээний чиглэлээр:

2014 оны судалгааны үр дүнгийн тооцооллыг гаргаж тайланг боловсрууллаа. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн үнэлгээ 3.58 гарсныг парламентад суудалтай намууд болон төрийн захиргааны төв, хууль сахиулах байгууллагууд, шүүхийн төлөөлөлд танилцуулж, хэлэлцүүлэх уулзалт болон төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгааны үр дүнг судалгаанд хамрагдсан байгууллагуудын төлөөлөлд танилцуулах ажлыг тус тус зохион байгуулав.

“Монгол Улсын Авлигын индекс тооцох аргачлал”-ыг боловсронгуй болгох зорилгоор яам, агентлаг болон судалгааны байгууллагын төлөөллийг оролцуулсан

нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгийн мөрөөр холбогдох засвар өөрчлөлтийг аргачлалын төсөлд тусгахаар ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулан явуулдаг судалгаануудын талаар танилцуулга бэлтгэж Газрын удирдлага болон бусад байгууллага /СЯам, УБЕГ, Налайх дүүргийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж/-д танилцуулав.

Транспарэнси интернэшнл байгууллагын “Авлигын төсөөллийн индекс”, Азийн сангийн “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”, “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаа”, Үндэсний статистикийн хорооны “Ардчилсан засаглал”, Дэлхийн санхүүгийн шударга байдал байгууллагын “Хөгжиж буй улс орнуудаас хууль бусаар гадагш шилжсэн санхүүгийн урсгал судалгаа”, Базелийн институтын “Мөнгө угаах индекс”, МҮХАҮТ-ийн “Хүнд суртлын индекс”-ийн талаар танилцуулга бэлтгэсэн.

Гадаадын хэвлэл, мэдээлэлд гарсан авлигын талаарх мэдээ, мэдээлэл, нийтлэлээс түүвэрлэн орчуулж 12 удаагийн тойм (2014 оны №50, 2015 оны №1-11) бэлтгэн Газрын удирдлагад танилцуулав. Индонез, Австрали, Хонконг, Өмнөд Солонгос улсын танилцуулгыг бэлтгэж байна.

Мөрдөн шалгах хэлтэст сүүлийн гурван жилийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг, зөрчилд хийх шинжилгээний удирдамжийн төслийг боловсруулан 2015 оны 1 дүгээр сард хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж байна.

Зөрчлийн тухай /Захиргааны хариуцлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга/ хууль, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, түүний үзэл баримтлал, танилцуулга, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Хохирлын сангийн тухай, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төсөл, “Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 2 дугаар илтгэл”, Олон нийтийн харилцааны дэд зөвлөлөөс өгсөн зөвлөмж, “Хямралын (эрсдлийн) удирдлагын төлөвлөгөө” боловсруулах ажлын хүрээнд санал боловсруулж хүргүүлээ.

Хяналт шалгалт, дүн шинжилгээний чиглэлээр:

2014 оны ХАСХОМ мэдүүлбэл зохих 270 мэдүүлэг гаргагчийн 268 нь хуульд заасан хугацаандаа мэдүүлсэн байна. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв 113 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2015 оны тайлан /ХАСХОМ 1,2, 3 болон бичмэл тайлан/ мэдээг цаасаар болон цахим хэлбэрээр гаргуулан авч нэгтгэв.

Авлигатай тэмцэх газрын 119 мэдүүлэг гаргагчийн 2014 оны ХАСХОМ-ийг цаасаар болон цахим хэлбэрээр хүлээн авч бүртгэн, мөн 2014 онд шинээр

томилогдсон, хөрөнгө, орлогод нь орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн мэдүүлэг гаргагчдын мэдүүлгийг нэрсийн жагсаалтын хамт УИХ-ын ХЗБХороонд хүргүүллээ.

Улсын хэмжээнд 38423 хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 38422 мэдүүлэг гаргагч буюу 99,99 хувь нь бүртгүүлсэн. Үүнээс хуульд заасан хугацаандаа 38421 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн бол 1 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулж, 1 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж өгөхөөс татгалзсан бөгөөд нийт мэдүүлэг гаргагчдын 15970 буюу 41,56 хувь нь Улаанбаатар хотод, 22453 буюу 58,44 хувь нь орон нутагт байна. Мэдүүлэг гаргагчдын тоо 13161-ээр буурсан үзүүлэлттэй байна.

Тайлангийн хугацаанд нийт 188 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахаас 175 мэдүүлгийг шалгаж дууссан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 36-гаар буюу 125,8 хувиар илүү байгаа бөгөөд 13 албан тушаалтны мэдүүлэг ажиллагаанд шалгагдаж байна.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 26-аар буюу 21,3 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол нь 18-аар буюу 20,2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 2912 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 2831 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлж, 81 мэдүүлэг ажиллагаанд хянагдаж байна.

Мөрдөн шалгах үйл ажиллагааны чиглэлээр:

Тайлангийн хугацаанд нийт 286 гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 108 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.1%-иар өссөн байна. Гэмт хэргийн шинжтэй 2014 оны үлдэгдэл 12 гомдол, шинээр хүлээн авсан 108 гомдол, нийт 120 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 24 гомдол, мэдээлэл буюу 20.0%-д эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5%-иар өссөн, 66 гомдол, мэдээлэл буюу 55.0%-д эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.8%-иар өссөн, 13 гомдол, мэдээлэл буюу 10.8%-ийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6%-иар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд ажиллагаанд 17 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 85.8%-тай байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг агуулга, холбогдох байгууллага, салбараар нь авч үзвэл нийтийн алба, төрийн албаны үйл ажиллагаанд хамаарах 109 гомдол, мэдээллээс төрийн улс төрийн албанд хамаарах 21, төрийн захиргааны албанд хамаарах 57, төрийн тусгай албанд хамаарах 23, төрийн үйлчилгээний албанд хамаарах 8 гомдол, мэдээлэл, бусад салбарт хамаарах 11

гомдол, мэдээлэл байх бөгөөд бусад салбарт хамаарах 11 гомдол мэдээллээс хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хамаарах 3, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 2, бусад 6 гомдол, мэдээлэл хамааран шалгагдсан.

Тайлангийн хугацаанд хуульд заасан харьяаллын 146 үйлдэлтэй, 125 холбогдогчтой 101 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан ба мөрдөн байцаалт явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилвал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 38 буюу 37.6 хувь, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 11 буюу 10.9 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 11 буюу 10.9 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 5 буюу 4.9 хувь, хээл хахууль авах 15 буюу 14.9 хувь, хээл хахууль өгөх 6 буюу 5.9 хувь, хээл хахуульд зуучлах 1 буюу 0.9 хувь, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 3 буюу 2.9 хувь, бусад хэрэг 11 буюу 10.9 хувийг эзэлж байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 17 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 16.8 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 18 хэргийг буюу 17.8 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 8 хэргийг буюу 7.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх, 10 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж, 6 хэргийг буюу 5.9 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, одоо 42 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг 5-аар буюу 5.2 хувиар өссөн, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 4-өөр буюу 19.0 хувиар буурсан, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 4-өөр буюу 28.6 хувиар, харьяаллын дагуу шилжүүлсэн хэрэг 2-оор буюу 33.3 хувиар тус тус өссөн, ажиллагаанд байгаа хэрэг 7-оор бага буюу 14.3 хувиар буурсан дүнтэй байна.

Мөрдөн шалгасан хэргийн 49 хэргийг буюу 48.5 хувийг шийдвэрлэсэн, хуулийн анхны хугацаанд хэрэг шийдвэрлэлт 30.6 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас 26 тэрбум 176.4 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 393.8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 3 тэрбум 950 сая төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалж, 240.5 сая төгрөгийн нуугдмал мөнгө, эд хөрөнгө илрүүлсэн байна.